

МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр

Дугаар 408

Улаанбаатар хот

Үнэт цаасны бүртгэлийн журам  
шинэчлэн батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6.4, 8.2, 10.16, 16.2, 17.2, 18.2-т заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Энэхүү тогтоолыг 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсүгэй.
3. Энэхүү тогтоолыг дагаж мөрдсөн өдрөөс Хорооны 2014 оны 06 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ыг хүчингүй болсонд тооцсугай.
4. Журам батлагдсантай холбогдуулан холбогдох дүрэм, журамдаа зохих өөрчлөлтийг оруулан 2015 оны 12 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Хороогоор батламжлуулахыг “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК /М.Болор/, “Монголын үнэт цаасны бирж” ХХК /С.Даваасамбуу/, “ҮЦТТТХТ” ХХК /Ж.Алдаржавхлан/-д тус тус үүрэг болгосугай.
5. Энэхүү тогтоолыг олон нийгэд мэдээллэхийг Тамгын газар /П.Алтан-Од/-т, зохицуулалттай этгээдүүдийн хүрээнд сургалт зохион байгуулах, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны зохицуулалтын газар /Т.Гандулам/-т тус тус даалгасугай.

ДАРГА

З.НАРАНТУЯА

## ҮНЭТ ЦААСНЫ БҮРТГЭЛИЙН ЖУРАМ

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмын зорилго нь Санхүүгийн зохицуулах хороо /цаашид Хороо гэх/-ноос компанийн шинээр болон нэмж гаргасан хувьцаа, өрийн хэрэгсэл /цаашид “үнэт цаас” гэх/-ийг нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэл /цаашид “Хорооны бүртгэл” гэх/-д бүртгэхэд үнэт цаас гаргагч, арилжаа эрхлэх байгууллага, Хорооны эрх, үүргийг тодорхойлох, хувьцаа, өрийн хэрэгслийг бүртгүүлэх хүсэлт гаргах, хүсэлтийг хянах, бүртгэхээс татгалзах, бүртгэсэн үнэт цаасыг нийтэд танилцуулах, анхдагч зах зээлд арилжих, тайлагнах, Хорооны бүртгэлд өөрчлөлт оруулах, бүртгэлээс хасахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Үнэт цаасыг арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлд бүртгэхтэй холбоотой харилцааг арилжаа эрхлэх байгууллагын ‘Бүртгэлийн журам’-аар зохицуулна.

1.3. Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, хадгаламжийн бичиг гаргах болон бусад үүсмэл санхүүгийн хэрэгсэлийг бүртгэх харилцааг нь тус тусын үйл ажиллагааг нь тусгайлан зохицуулсан Хорооны журмаар зохицуулагдана.

### ХОЁР. НЭР ТОМЪЁО

2.1. Энэхүү журмын дор дурдсан нэр томъёог дараах утга агуулгаар ойлгож, хэрэглэнэ.

2.1.1. “Хорооны бүртгэл” гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон энэ журамд заасны дагуу Хорооноос нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлийг;

2.1.2. “Арилжаа эрхлэх байгууллагын бүртгэл” гэж арилжаа эрхлэх байгууллага Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1.2 дахь хэсэгт заасны дагуу өөрийн баталсан журмаар тогтоосон ангиллын шалгуурыг хангасан үнэт цаасыг арилжаалахыг зөвшөөрч бүртгэсэн үнэт цаасны бүртгэлийг;

2.1.3. “үнэт цаас гаргагч” Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.20-д заасан этгээд болон үнэт цаасаа арилжаа эрхлэх байгууллагад бүртгүүлэх, Хороонд бүртгүүлсэн үнэт цаасны бүрдүүлбэрт өөрчлөлт оруулах, эсхүл бүртгэлээс хасуулах хүсэлт гаргаж буй хуулийн этгээдийг;

2.1.4. “үнэт цаасны бүрдүүлбэр” гэж дараах цогц мэдээллийг

2.1.4.1. үнэт цаасны төрөл;

2.1.4.2. үнэт цаас гаргагчийн оноосон нэр;

2.1.4.3. үнэт цаасны нэрлэсэн үнэ;

2.1.4.4. зарласан үнэт цаасны тоо ширхэг;

2.1.4.5. эргэлтэд гаргасан үнэт цаасны тоо ширхэг;

2.1.4.6. арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй эсэх;

2.1.4.7. өрийн хэрэгсэлийн хүү, хугацаа, төрөл;

2.1.4.8. өрийн хэрэгсэлийн хүү төлөгдөх нөхцөл;

2.1.4.9. үнэт цаасны төлбөр хийгдэх нөхцөл.

2.1.5. "Захиалгын бүртгэл" гэж анхдагч зах зээлд гаргасан үнэт цаасыг худалдан авах саналын бүртгэлийг.

### ГУРАВ. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ, АРИЛЖАА ЭРХЛЭХ БАЙГУУЛЛАГА, ХОРООНЫ ЭРХ, ҮҮРЭГ

#### **3.1. Үнэт цаас гаргагч нь дараах эрхийг эдэлж, үүрэг хүлээнэ:**

3.1.1. Үнэт цаас гаргагч нь анх удаа нийтэд санал болгох үнэт цаас гаргах бол энэ тухай хүсэлтээ Хороо болон арилжаа эрхлэх байгууллагад нэгэн зэрэг гаргаж бүртгүүлнэ.

3.1.2. Үнэт цаас гаргагч нь энэхүү журмын 3.2.7-д заасан арилжаа эрхлэх байгууллагын шийдвэрийг эс зөвшөөрвөл Хороонд гомдол гаргах эрхтэй.

3.1.3. Үнэт цаас гаргагч нь үнэт цаасыг бүртгэхээс татгалзсан тухай Хорооны шийдвэрийг эс зөвшөөрвөл Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд зааснаар Хорооны Хяналтын зөвлөлд гомдол гаргах эрхтэй.

3.1.4. Үнэт цаас гаргагч нь нийтэд санал болгон гаргах үнэт цаасыг тодорхой үнэ, хувь хэмжээгээр худалдан авах эрхийг гэрчлэх варрант гаргах эрхтэй.

3.1.5. Үнэт цаас гаргагч нь үнэт цаасаа бүртгүүлэх, бүрдүүлбэрт өөрчлөлт оруулах эсхүл бүртгэлээс хасуулахтай холбоотой Хороонд гаргасан хүсэлтээ хэрхэн шийдвэрлэгдэж байгаа талаарх явцын мэдээ, мэдээллээр хангагдах эрхтэй.

3.1.6. Үнэт цаас гаргагч нь үнэт цаасны бүрдүүлбэрт өөрчлөлт оруулах, компанийн хэлбэрийг өөрчлөх, өрийн хэрэгсэл гаргагч нь үнэт цаасны үндсэн болон хүүгийн төлбөрийг бүрэн төлж, барагдуулан үнэт цаасаа бүртгэлээс хасуулах тохиолдолд энэ тухай хүсэлтээ арилжаа эрхлэх байгууллагад тэргүүн ээлжинд гаргана.

3.1.7. Үнэт цаас гаргагч нь нийтэд санал болгон гаргах үнэт цаасыг бүртгэхтэй холбоотой Хорооноос шаардсан тодруулга, нэмэлт баримт бичгийг заасан хугацаанд хүргүүлэх үүрэгтэй.

3.1.8. Төсөл хэрэгжүүлэх зорилго бүхий үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжиж эхэлсэнээс хойш дуусах хүртэл хугацаанд улирал бүр төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын зардлын зүйл, ангилал тус бүрээр нягтлан бодох бүртгэлийн хууль, тогтоомжид нийцүүлэн гаргасан дэлгэрэнгүй тайланг санхүүгийн тайлангийн хамт дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор Хороонд хүргүүлэхээс гадна өөрийн болон арилжаа эрхлэх байгууллагын цахим хуудсаар дамжуулан нийтэд тогтмол мэдээлэх үүрэгтэй.

3.1.9. Үнэт цаас гаргагч нь компанийн засаглалын кодексийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах бөгөөд хувьцаа эзэмшигчийн эрх, ашгийг хамгаалах чиглэлээр компанийн ногдол ашгийн бодлогыг боловсруулан баталж, мөрдөх үүрэгтэй.

3.1.10. Үнэт цаас гаргагч нь өрийн хэрэгслийн барьцаа хөрөнгийн бүртгэлийг барьцааны эд хөрөнгийг бүртгэх төрийн эрх бүхий байгууллагад бүртгүүлэх үүрэгтэй.

3.1.11. Үнэт цаас гаргагч нь арилжаа эрхлэх байгууллага болон Хороонд хүргүүлсэн үнэт цаасны танилцуулга, түүнд хавсаргасан холбогдох бүх баримт бичиг, хөндлөнгийн шинжээчдийн дүгнэлт зэрэг үнэт цаас бүртгүүлэхтэй холбоотой материалыг Хорооны бүртгэлд бүртгэх тухай тогтоол гарснаас хойш арван жилийн хугацаанд компани дээрээ хадгалах үүрэгтэй.

### **3.2.Арилжаа эрхлэх байгууллага дараахэрхийг эдлэж, үүрэг хүлээнэ:**

3.2.1. Арилжаа эрхлэх байгууллага нь өөрийн бүртгэлийн шаардлага, шалгуурыг хангаагүй, түүний өмнө гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй үнэт цаас гаргагчийн үнэт цаасыг өөрийн бүртгэлээс хасах эрхтэй.

3.2.2. Арилжаа эрхлэх байгууллага нь үнэт цаасны бүртгэлийн ангиллын шалгуур үзүүлэлтийг үнэт цаас гаргагч хангаж байгаа эсэх, санхүүгийн үзүүлэлт нь үнэн зөв, бодитой эсэх, бизнес төлөвлөгөө болон түүний эдийн засгийн үндэслэл, нийтэд санал болгож байгаа үнэт цаасны танилцуулгын бүрдэл зэргийг хянах үүрэгтэй.

3.2.3. Арилжаа эрхлэх байгууллага нь энэ журмын 3.2.2-д заасан ажиллагааг ажлын 14 өдрийн дотор гүйцэтгэх бөгөөд тухайн үнэт цаас гаргагчийн үнэт цаасыг өөрийн арилжааны бүртгэлийн жагсаалтад оруулахыг зөвшөөрч шийдвэрлэсэн тохиолдолд уг шийдвэрээ энэхүү журмын 2 дугаар хавсралтад заасан дүгнэлтийн хамт ажлын хоёр өдрийн дотор Хороонд хүргүүлэх үүрэгтэй.

3.2.4. Гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй үнэт цаас гаргагч нь дотоодын арилжаа эрхлэх байгууллагад бүртгүүлэн үнэт цаасаа нийтэд санал болгох хүсэлт гаргах тохиолдолд энэхүү журмын 3.2.2 дах заалт нэгэн адил хамаарна.

3.2.5. Арилжаа эрхлэх байгууллага нь өрийн хэрэгсэлийн үндсэн болон хүүгийн төлбөрийн эргэн төлөлтийн баталгаа, барьцаа хөрөнгийн бүртгэлийг хөтлөх үүрэгтэй бөгөөд тухайн өрийн хэрэгслийн төлбөрийн эргэн төлөлтөд хяналт тавих үүрэгтэй.

3.2.6. Үнэт цаас гаргагч нь үнэт цаасны бүрдүүлбэрт өөрчлөлт оруулахаар хүсэлт гаргаж, арилжаа эрхлэх байгууллага уг хүсэлтийг өөрийн журмын дагуу хянаж, бүртгэлд өөрчлөлт оруулахыг зөвшөөрсөн тохиолдолд гаргасан шийдвэрийг энэхүү журмын 2 дугаар хавсралтад заасан дүгнэлт, 'Бүртгэв' тэмдэглэл бүхий үнэт цаас гаргагчийн ирүүлсэн баримт бичгийн хуулбарын хамт ажлын хоёр өдрийн дотор Хороонд хүргүүлэх үүрэгтэй.

3.2.7. Арилжаа эрхлэх байгууллага нь үнэт цаас гаргагчийн анх удаа болон нэмж гаргах үнэт цаасыг бүртгүүлэх болон бүртгэлээс хасуулах хүсэлтээс татгалзсан тохиолдолд энэ тухай гаргасан шийдвэрийг татгалзах болсон шалтгаан, тайлбартай хамт ажлын гурван өдрийн дотор үнэт цаас гаргагч болон Хороонд хүргүүлэх үүрэгтэй.

3.2.8. Үнэт цаас гаргагч нь энэхүү журмын 3.1.6-д заасны дагуу арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлээс үнэт цаасаа хасуулах хүсэлт гаргасан тохиолдолд арилжаа эрхлэх байгууллагын зүгээс тухайн үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн эрхийг хуульд заасан хугацаанд хангасан эсэхэд хяналт тавих үүрэгтэй.

3.2.9. Арилжаа эрхлэх байгууллага нь үнэт цаас бүртгэлээс хасагдсан тухай шийдвэрийг энэхүү журмын 4 дүгээр хавсралтад заасан дүгнэлт, 'Бүртгэв' тэмдэглэл бүхий үнэт цаас гаргагчийн ирүүлсэн баримт бичгийн хуулбарын хамт ажлын хоёр өдөрт багтаан Хороонд хүргүүлэх үүрэгтэй.

3.2.10. Арилжаа эрхлэх байгууллага нь энэхүү журмын 3.2.1-д заасан шалтгаанаар үнэт цаасыг өөрийн бүртгэлээс хасахаар шийдвэрлэсэн тохиолдолд энэ тухай мэдэгдэл, холбогдох шийдвэрийг ажлын хоёр өдөрт багтаан үнэт цаас гаргагч болон Хороонд хүргүүлэх үүрэгтэй.

### **3.3.Хороо нь дараах эрхийг эдэлж, үүрэг хүлээнэ:**

3.3.1. Үнэт цаас гаргагчийн үнэт цаасыг бүртгэх, бүртгэлтэй үнэт цаасны хувьд энэхүү журмын 3.3.2-д зааснаас бусад бүрдүүлбэрт өөрчлөлт оруулах, үнэт цаасыг бүртгэлээс хасах шийдвэрийг Хорооны тогтоолоор батална.

3.3.2. Энэхүү журмын 2.1.4.2, 2.1.4.4, 2.1.4.6-д заасан бүрдүүлбэрт орох өөрчлөлтийг Хорооны даргын тушаалаар бүртгэнэ.

3.3.3. Энэхүү журмын 3.1.2-д заасны дагуу үнэт цаас гаргагчаас Хороонд гомдол гаргасан тохиолдолд Хороо нь арилжаа эрхлэгч байгууллагын шийдвэрийг үндэслэлтэй эсэхийг хянах бөгөөд арилжаа эрхлэх байгууллагаас уг асуудалтай холбоотой нэмэлт тайлбар, шаардлагатай мэдээллийг шаардаж болно.

3.3.4. Хороо нь энэхүү журмын 3.2.1-д заасан үндэслэлээр арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлээс хасагдсан үнэт цаас гаргагчийн үнэт цаасыг хаалттай хувьцаат компанийн үнэт цаасны бүртгэлд бүртгэнэ.

## **ДӨРӨВ. НИЙТЭД САНАЛ БОЛГОН АНХ УДАА ГАРГАХ ҮНЭТ ЦААСЫГ БҮРТГЭХ**

### **4.1.Хорооны бүртгэлд бүртгүүлэх хүсэлт гаргах:**

4.1.1. Үнэт цаас гаргагч нь үнэт цаасаа бүртгүүлэх хүсэлтийг Хороонд гаргахдаа дараах баримт бичгийг хавсаргана. Үүнд:

4.1.1.1. үнэт цаасыг бүртгүүлэх өргөдөл /Хавсралт 1-д заасан Маягт - СЗХ03101-ын дагуу/;

4.1.1.2. арилжаа эрхлэх байгууллагыг шаардлагад нийцүүлэн боловсруулсан үнэт цаасны танилцуулга;

4.1.1.3. үнэт цаас гаргах, түүнд өөрчлөлт оруулах тухай хувьцаа эзэмшигчдийн хурлаас гаргасан шийдвэр, холбогдох нотлох баримт бичиг;

4.1.1.4. энэхүү журмын 4.2.2-т заасан хууль зүйн дүгнэлт;

4.1.1.5. үнэлгээ, аудитын байгууллагаас арилжаа эрхлэх байгууллагын шаардлагад нийцүүлэн гаргасан дүгнэлт;

4.1.1.6. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.8 дахь хэсэгт заасан хөндлөнгийн шинжээч, мэргэжилтэн үнэлэлт, дүгнэлт гаргасан бол тэдгээрийн дүгнэлт;

4.1.1.7. зохицуулалтын үйлчилгээний хөлс болон улсын тэмдэгтийн хураамж төлсөн тухай төлбөрийн баримт.

4.1.2. Гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд дотоодын арилжаа эрхлэх байгууллага болон Хороонд бүртгүүлэн үнэт цаасаа нийтэд арилжаалахад энэхүү журам нэгэн адил хамаарна.

4.1.3. Дотоодын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй үнэт цаас гаргагч хувьцаагаа гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгүүлэн арилжаалж болох бөгөөд энэ талаар аливаа мэдэгдэл хийхээс өмнө дотоодын арилжаа эрхлэх байгууллагад бүртгүүлж, Хороонд мэдэгдэнэ.

4.1.4. Дотоодын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй үнэт цаас гаргагч нь энэхүү журмын 4.1.3-т зааснаар Хороонд мэдэгдэл хүргүүлэхдээ гадаад улсын зохицуулах байгууллагад хувьцаагаа бүртгүүлэхэд шаардлагатай бичиг баримтын хуулбарыг Хороонд хүргүүлнэ.

4.1.5. Үнэт цаас гаргагч нь гадаад улсын зохицуулах байгууллага, арилжаа эрхлэх байгууллагад үнэт цаасаа бүртгүүлсэн тохиолдолд тэдгээр байгууллагын шийдвэрийн хувийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын таван өдөрт багтаан Хороонд хүргүүлнэ.

4.1.6. Энэхүү журмын 4.1.3-т заасан үнэт цаас гаргагч нь анхдагч зах зээлд арилжигдсан үнэт цаасны хэмжээ, үнэ, зах зээлээс татан төвлөрүүлсэн хөрөнгийн нийт дүнгийн талаарх мэдээ, тайланг тухайн улсын холбогдох байгууллагад хүргүүлсэнээс хойш ажлын таван өдөрт багтаан Хороонд хүргүүлнэ.

4.1.7. Хороо энэхүү журмын 4.1.5-д заасан шийдвэрийн хувийг хүлээн авсан нь тухайн үнэт цаасыг Хорооны бүртгэлд бүртгэх үндэслэл болно.

## **4.2. Үнэт цаас гаргагчийн хүсэлтийг хянах:**

4.2.1. Хороо нь энэхүү журмын 3.2.3, 4.2.2-д тус тус заасан дүгнэлт холбогдох хууль тогтоомжид нийцэж буй эсэхийг хянана.

4.2.2. Үнэт цаас гаргагч нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.1 дахь заалтад заасан шалгуурыг хангасан хууль зүйн зөвлөгөө өгөх үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдтэй гэрээ байгуулж, дүгнэлт гаргуулах бөгөөд дүгнэлтэд дараах асуудлыг тусгасан байна. Үүнд:

- 4.2.2.1. үнэт цаас гаргагч нь хуулийн дагуу үүсгэн байгуулагдаж, бүртгэгдсэн эсэх;
- 4.2.2.2. төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтан нь холбогдох хууль тогтоомж болон Хорооноос баталсан “Монголын компанийн засаглалын кодекс”-т заасан шаардлага хангасан болон гэмт хэрэгт холбогдож байсан эсэх, тэдгээрийн удирдах чадвар, дадлага туршлагын байдал;
- 4.2.2.3. үнэт цаас гаргагчийн дүрэм, дотоод журмууд нь холбогдох хууль тогтоомж, Хорооноос баталсан “Монголын компанийн засаглал кодекс”-т нийцсэн эсэх;
- 4.2.2.4. бусадтай байгуулсан худалдах болон худалдан авах, бэлтгэн нийлүүлэх, зээлийн гэрээ болон үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх бусад гэрээ, контракт нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэх;
- 4.2.2.5. сүүлийн 3 жил дотор хийгдсэн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл нь холбогдох хууль, тогтоомжийн дагуу хийгдсэн эсэх;
- 4.2.2.6. үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, лиценз, зохиогчийн эрх, патент, бараа, үйлчилгээний тэмдэг нь хүчин төгөлдөр эсэх, тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах,

аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн зэргээр үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд нь бодитой нөлөөлж болохуйц нөхцөл буй эсэх;  
4.2.2.7. үнэт цаас, үл хөдлөх болон бусад эд хөрөнгө өмчлөх эрх нь хүчин төгөлдөр эсэх, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн эсэх;  
4.2.2.8. үнэт цаасыг бүртгүүлэх өргөдөл, танилцуулгад тусгагдсан мэдээлэл нь хүчин төгөлдөр баримтаар нотлогдож байгаа эсэх;  
4.2.2.9. компанийн толгой, охин, хараат, зэрэгцээ компанийн талаарх мэдээлэлд үндэслэн үнэт цаас гаргагч компанийн хяналтыг хэрэгжүүлэгч этгээдийг тодорхойлох;

4.2.3. Хороо энэхүү журмын 3.3.1-д заасан хуралдаанд арилжаа эрхлэх байгууллагын гүйцэтгэх захирал, үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтан болон энэхүү журмын 4.1.1.4-4.1.1.6-д заасан үнэлэлт, дүгнэлт гаргасан этгээдийг оролцуулан шаардлагатай нэмэлт тайлбар, тодруулгыг авч болно.

### **4.3. Хорооны бүртгэлд бүртгэх, бүртгэхээс татгалзах, үнэт цаасны танилцуулгыг олон нийтэд танилцуулах:**

4.3.1. Хороо нь энэхүү журмын 3.2.3-т заасан арилжаа эрхлэх байгууллагын дүгнэлт, 4.2.2-т заасан хууль зүйн зөвлөгөө өгөх үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн дүгнэлтийг тус тус хянаж, холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу бүртгэхээс татгалзах үндэслэлгүй бол үнэт цаас гаргагчийн үнэт цаас, түүний танилцуулгыг Хорооны хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

4.3.2. Засгийн газар бүхэлд нь баталгаа гаргасан үнэт цаасыг бүртгэх, гаргасан хувьцааг нэгтгэх эсхүл хуваах замаар бүрдүүлбэрт өөрчлөлт оруулахад арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлийг үндэслэн Хорооны бүртгэлд бүртгэнэ.

4.3.3. Гаргасан хувьцааг нэгтгэх эсхүл хуваахад зарласан эсхүл халаасны хувьцааны бүрдүүлбэрт нэгтгэсэн эсхүл хуваасан хэмжээгээр дүйцүүлэн үнэт цаасны бүртгэлд холбогдох өөрчлөлтийг оруулна.

4.3.4. Хороо нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.10 дахь хэсэгт заасан тохиолдол бий болсон, эсхүл арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлд бүртгүүлээгүй үнэт цаас гаргагчийн үнэт цаасыг бүртгэхээс татгалзана.

4.3.5. Хороо нь үнэт цаас, түүний танилцуулгыг бүртгэх тухай шийдвэрийг үнэт цаас гаргагч, арилжаа эрхлэх болон үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад тус тус хүргүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлнэ.

4.3.6. Хороо нь үнэт цаасыг ямар нэгэн нөхцөл болзолтойгоор бүртгэхгүй.

4.3.7. Хороо нь үнэт цаасыг бүртгэх үед компанийн хяналтын багцыг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчийн үнэт цаасыг тодорхой хугацаанд Хорооны шийдвэрээр тусгаарлаж болох бөгөөд тусгаарлалтын хугацааг нэг удаа сунгаж болно.

4.3.8. Энэхүү журмын 4.3.7-д заасан тусгаарлагдсан хувьцааг тусгаарлалтаас чөлөөлөх нөхцөл бүрдсэн гэж үзвэл чөлөөлөх тухай Хорооны тогтоол гаргана.

4.3.9. Хорооны бүртгэлд бүртгүүлээгүй үнэт цаасыг нийтэд санал болгохыг хориглоно.

4.3.10. Стратегийн хөрөнгө оруулагч болон мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэгч этгээд, андеррайтерийн компанитай үнэт цаасыг анхдагч зах зээлд байршуулах, худалдах асуудлаар урьдчилан хэлэлцээр хийснийг нийтэд санал болгосонд тооцохгүй.

4.3.11. Үнэт цаас гаргагч болон түүний андеррайтер нь Хороонд бүртгүүлсэн үнэт цаасны танилцуулгыг нийтэд үнэ төлбөргүй хүргэх бөгөөд сонирхсон бүх этгээдийг танилцах боломжоор хангасан байна.

4.3.12. Хорооны бүртгэлд бүртгэгдсэн танилцуулгад тусгагдсанаас өөр агуулгатай мэдээлэл, нэмэлт мэдээлэл олон нийтэд түгээхийг хориглоно.

#### **4.4. Анхдагч зах зээлд арилжаалах, тайлагнах, бүртгэлийг хүчингүй болгох:**

4.4.1. Үнэт цаас гаргагч болон андеррайтер нь үнэт цаасыг Хороонд бүртгүүлсэнээс хойш зургаан сарын хугацаанд анхдагч зах зээлд гарган нийтэд санал болгон арилжаална.

4.4.2. Үнэт цаасыг нийтэд танилцуулах ажиллагаа дуусгавар болсон үед Хороонд бүртгэгдсэн танилцуулгад заасан арга хэлбэрээр үнэт цаасыг анхдагч зах зээлд байршуулна.

4.4.3. Андеррайтер, эсхүл үнэт цаас гаргагч нь үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааг, эсхүл захиалгын бүртгэлийг эхлүүлэх зөвшөөрлийг Хорооноос авах ба энэ тухай хүсэлтийг уг ажиллагааг эхлүүлэхээс ажлын гурваас доошгүй өдрийн өмнө Хороонд гаргах бөгөөд хүсэлтэд хугацаа, хуваарийг тодорхой тусгагдсан байна.

4.4.4. Анхдагч зах зээлд байршуулахаар захиалгын бүртгэл хийх, эсхүл арилжаалагдах хугацаа нь захиалгын бүртгэл эхэлсэн, эсхүл үнэт цаасыг нийтэд санал болгон арилжаалж эхэлсэн өдрөөс хойш нэг сараас илүүгүй байна.

4.4.5. Нийтэд санал болгон нэмж гаргах үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаанд энэхүү журмын 4.4.1, 4.4.4-т заасан хугацаа нэгэн адил хамаарна.

4.4.6. Анхдагч зах зээлийн арилжааг өрийн хэрэгслийн хувьд Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.7 дахь хэсэгт заасан нөхцөлд, хувьцааны хувьд хуульд заасан болон дараах нөхцөлд амжилттай явагдсанд тооцно.

4.4.6.1. нийт 50 болон түүнээс дээш хөрөнгө оруулагч хувьцааг худалдан авсан;

4.4.6.2. үнэт цаасны танилцуулгад заасан хувь, хэмжээгээр арилжаалж, шаардагдах хэмжээний санхүүжилтийг татан төвлөрүүлсэн.

4.4.7. Хороо энэхүү журмын 4.4.6.2-т заасан болон түүнээс дээш хэмжээнд арилжаалагдсан хувьцааг компанийн гаргасан хувьцааны, үлдэх хувьцааг зарласан хувьцааны бүртгэлд тус тус бүртгэнэ.

4.4.8. Үнэт цаас гаргагч нь үнэт цаасаа анхдагч зах зээлд тодорхой хэмжээгээр багцлан арилжаалж болно.

4.4.9. Үнэт цаас гаргагч нь энэхүү журмын 3.1.4-т заасны дагуу варрант гаргасан бол уг санхүүгийн хэрэгслийг эзэмшигч нь анхдагч зах зээлийн арилжаа, эсхүл захиалгын бүртгэл явагдаж дуусахаас өмнө үнэт цаасны зохих төлбөрийг гүйцэтгэсэн байна.

4.4.10. Варрант эзэмшигч нь үнэт цаас худалдан авах эрхээ тодорхой нөхцлөөр бусдад шилжүүлж болох бөгөөд энэ тохиолдолд эрх хүлээн авагч нь энэхүү журмын 4.4.9-д заасан хугацаанд үнэт цаасны зохих төлбөрийг гүйцэтгэнэ.

4.4.11. Андеррайтер нь анхдагч зах зээлийн арилжаа, эсхүл захиалгын бүртгэл явагдаж дууссанаас хойш ажлын гурван өдөрт багтаан арилжааны тайланг энэхүү журмын 3 дугаар хавсралтын дагуу Хороонд хүргүүлнэ.

4.4.12. Энэхүү журмын 4.4.6-д заасан нөхцөл бүрдээгүй тохиолдолд Хороо нь тухайн үнэт цаасны бүртгэлийг хүчингүй болгож, анхдагч зах зээлийн хэлцлийг буцаана.

4.4.13. Хороо нь энэхүү журмын 4.4.11-т заасан тайланг хүлээн авч анхдагч зах зээлийн захиалгын бүртгэл болон арилжаа амжилттай явагдсан, аливаа зөрчил гараагүй гэж үзвэл үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад өмчлөх эрхийн бүртгэл хийх болон арилжаа эрхлэх байгууллагад үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх зөвшөөрлийг тус тус олгох тухай албан бичгийг ажлын гурван өдөрт багтаан хүргүүлнэ.

4.4.14. Үнэт цаас гаргагч нь энэхүү журмын 4.4.11-т заасан хугацаанд багтаж үнэт цаасны гүйлгээний товч тайланг нийтэд мэдээнэ. Хэрэв нээлттэй компани болон өөрчлөгдөж анх удаагаа хувьцаагаа нийтэд санал болгон худалдсан бол уг мэдээлэлд компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын товыг тусгасан байна.

## ТАВ. ҮНЭТ ЦААСНЫ БҮРТГЭЛД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ

### **5.1. Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах:**

5.1.1. Үнэт цаас гаргагчийн үнэт цаасны бүрдүүлбэрт өөрчлөлт оруулах шийдвэрийг хууль болон тухайн компанийн дүрэмд заасан эрх бүхий байгууллага гаргана.

5.1.2. Үнэт цаас гаргагч нь үнэт цаасны бүрдүүлбэрт өөрчлөлт оруулах хүсэлтийг энэхүү журмын 3.1.6-д заасны дагуу арилжаа эрхлэх байгууллагад тэргүүн ээлжинд гарган бүртгүүлэх бөгөөд Хороо тус компанийн нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд орох өөрчлөлтийг бүртгэнэ.

### **5.2. Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах хүсэлт гаргах, хүсэлтийг хянах, Хорооны бүртгэлд өөрчлөлт оруулах:**

5.2.1. Үнэт цаас гаргагч нь үнэт цаасны бүрдүүлбэрт өөрчлөлт оруулах хүсэлтийг Хороонд гаргахдаа дараах баримт бичгийг хавсаргана. Үүнд:

5.2.1.1. үнэт цаасны бүрдүүлбэрт орох өөрчлөлтийг бүртгүүлэх өргөдөл /Хавсралт 1-д заасан Маягт - СЗХ03101-ын дагуу/;

5.2.1.2. үнэт цаас гаргах, түүнд өөрчлөлт оруулах тухай эрх бүхий этгээдийн гаргасан шийдвэр, холбогдох нотлох баримт бичиг;

5.2.1.3. энэхүү журмын 5.2.2-т заасан хууль зүйн дүгнэлт;

- 5.2.1.4. Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагын албан ёсны мэдээнд тусгасан сүүлийн зургаан сарын жигнэсэн дундаж ханшийн албан ёсны мэдээ;
- 5.2.1.5. зохицуулалтын үйлчилгээний хөлс төлсөн тухай төлбөрийн баримт.

5.2.2. Үнэт цаас гаргагч нь үнэт цаасны энэхүү журмын 3.3.2-т зааснаас бусад бүрдүүлбэрт өөрчлөлт оруулахтай холбоотой асуудлаар Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.1 дахь заалтад заасан шалгуурыг хангасан хууль зүйн зөвлөгөө өгөх үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдтэй гэрээ байгуулж, дүгнэлт гаргуулах бөгөөд дүгнэлтэд дараах асуудлыг тусгасан байна. Үүнд:

- 5.2.2.1. үнэт цаасны бүрдүүлбэрт өөрчлөлт оруулах шийдвэр нь холбогдох хууль, журамд нийцсэн эсэх;
- 5.2.2.2. бусадтай байгуулсан худалдах болон худалдан авах, бэлтгэн нийлүүлэх, зээлийн гэрээ болон үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх бусад гэрээ, контракт нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэх;
- 5.2.2.3. сүүлийн 3 жил дотор хийгдсэн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл нь холбогдох хууль, тогтоомжийн дагуу хийгдсэн эсэх;
- 5.2.2.4. үнэт цаасны бүрдүүлбэрт өөрчлөлт оруулах шийдвэр, түүнийг хэрэгжүүлэхтэй холбоотой ажиллагаа нь хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдийн хууль ёсны эрх ашигт нийцсэн эсэх.

5.2.3. Үнэт цаасны бүрдүүлбэрт өөрчлөлт оруулахтай холбоотойгоор үнэт цаас гаргагчийн Хороонд хүсэлт гаргахаас өмнөх сүүлийн гурван жилийн дотор хийлгэсэн хараат бус үнэлгээ, аудитын байгууллагын дүгнэлтийг ашиглаж болно.

5.2.4. Хороо нь энэхүү журмын 3.2.6-т заасан арилжаа эрхлэх байгууллагын дүгнэлт, 5.2.2-т заасан хууль зүйн зөвлөгөө өгөх үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн дүгнэлтийг тус тус хянаж, холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу бүртгэхээс татгалзах үндэслэлгүй бол үнэт цаас гаргагчийн үнэт цаасны бүрдүүлбэрт орох өөрчлөлтийг бүртгэх эсэх асуудлыг энэхүү журмын 3.3.1-д заасны дагуу Хороо шийдвэрлэн тогтоол гаргана.

5.2.5. Үнэт цаасны бүрдүүлбэрт өөрчлөлт оруулах тухай Хорооны шийдвэр гарсны дараа ажлын тав хоногт багтаан Хорооны Ажлын алба үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулж, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн байгууллагад мэдэгдэнэ.

## ЗУРГАА. ҮНЭТ ЦААСЫГ БҮРТГЭЛЭЭС ХАСАХ

### **6.1. Үнэт цаасыг Хорооны бүртгэлээс хасуулах хүсэлт гаргах, бүртгэлээс хасах:**

6.1.1. Үнэт цаас гаргагч нь компанийн хэлбэрийг өөрчлөх, татан буугдах, өрийн хэрэгсэл гаргагч нь үнэт цаасны үндсэн болон хүүгийн төлбөрийг бүрэн төлж, барагдуулсан болон хуульд заасан бусад тохиолдолд тухайн үнэт цаас гаргагчийн үнэт цаасыг Хорооны бүртгэлээс хасна.

6.1.2. Арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй эсхүл тухайн байгууллагын бүртгэлээс хасагдсан үнэт цаас гаргагч нь үнэт цаасаа бүртгэлээс хасуулахдаа дараах баримт бичгийг Хороонд хүргүүлнэ. Үүнд:

- 6.1.2.1. албан хүсэлт;
- 6.1.2.2. арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлээс хассан тухай шийдвэр;
- 6.1.2.3. үнэт цаасыг бүртгэлээс хасахад татгалзах зүйлгүй болохыг тодорхойлсон арилжаа эрхлэх байгууллагын тодорхойлолт;

6.1.2.4. үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагаас тухайн компанийн үнэт цаасыг бүртгэлээс хасахтай холбоотой санал, дүгнэлт, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлсэн эсэх тухай тодорхойлолт болон компанийн хувьцаа эзэмшигчийн тусгаарлагдсан хувьцааны талаарх мэдээ, мэдээлэл;

6.1.2.5. зохицуулалтын үйлчилгээний хөлс төлсөн төлбөрийн баримт.

6.1.3. Хороо нь энэхүү журмын 3.2.8-д заасан бүртгэлээс хасах тухай шийдвэр, журмын 4 дүгээр хавсралтын дагуу гаргасан арилжаа эрхлэх байгууллагын дүгнэлтийг тус тус үндэслэн үнэт цаас гаргагчийн үнэт цаасыг Хорооны бүртгэлээс хасна.

6.1.4. Компанийн хэлбэр өөрчлөгдсөн үнэт цаас гаргагчийн хувь эзэмшигчдийн дэлгэрэнгүй мэдээллийг үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага нь үнэт цаас гаргагч болон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн байгууллагад тус тус хүргүүлнэ.

6.1.5. Хороо нь үнэт цаасыг бүртгэлээс хассан тухай шийдвэрийг үнэт цаас гаргагч, арилжаа эрхлэх болон үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад тус тус хүргүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлнэ.

6.1.6. Үнэт цаасыг бүртгэлээс хасах тухай Хорооны шийдвэр гарахад Хорооны Ажлын алба энэ тухай ажлын 10 өдөрт багтаан хуулийн этгээдийн улсын бүртгэлийн байгууллагад мэдэгдэнэ.

## ДОЛОО. ХАРИУЦЛАГА

7.1. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд Үнэт цаасны зах зээлийн тухай болон бусад хууль тогтоомжид заасан хариуцлагыг Хорооны улсын байцаагч ногдуулна.

7.2. Энэхүү журмын 7.1-д заасан хариуцлага хүлээлгэсэн нь тухайн этгээдийн бусдын өмнө хүлээсэн үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

*Хавсралт 1: Нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасыг бүртгүүлэх тухай өргөдөл /Маягт СЗХ03101/*

*Хавсралт 2: Арилжаанд оруулахыг зөвшөөрсөн үнэт цаасыг бүртгэсэн, үнэт цаасны бүрдүүлбэрт өөрчлөлт оруулсан тухай дүгнэлт /Маягт СЗХ03102/*

*Хавсралт 3: Үнэт цаасыг анхдагч зах зээлд нийтэд санал болгосон тухай тайлан /Маягт СЗХ03103/*

*Хавсралт 4: Арилжаанд оруулахыг зөвшөөрсөн үнэт цаасыг бүртгэлээс хассан тухай дүгнэлт /Маягт СЗХ03104/*

Маягт СЗХ03101

**НИЙТЭД САНАЛ БОЛГОХЫГ ЗӨВШӨӨРСӨН  
ҮНЭТ ЦААСЫГ БҮРТГҮҮЛЭХ ТУХАЙ  
ӨРГӨДӨЛ**

Огноо: ...../...../.....

Он, сар, өдөр

Санхүүгийн зохицуулах хороонд

**1. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧТАЙ ХОЛБООТОЙ МЭДЭЭЛЭЛ**

Өргөдөл гаргагч хуулийн этгээдийн нэр оноосон нэр:	
Бүртгэлтэй улс, улсын бүртгэлийн дугаар:	
Регийтсрийн дугаар:	
Үйл ажиллагааны чиглэл:	
<b>1.1. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ ЭТГЭЭДИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ</b>	
Үүсгэн байгуулагч этгээд	<input type="checkbox"/> Хуулийн этгээд <input type="checkbox"/> Иргэн
<b>1.1.1. Хуулийн этгээд бол түүний нэр</b>	Монгол
	Англи
Үүсгэн байгуулагдсан огноо	Он      Сар      Өдөр
Хуулийн этгээдийн хэлбэр	<input type="checkbox"/> Хувьцаат компани <input type="checkbox"/> Хязгаарлагдмал хариуцлагатай компани
Хөрөнгө оруулалтын хэлбэр	<input type="checkbox"/> Дотоодын хөрөнгө оруулалттай <input type="checkbox"/> Гадаадын хөрөнгө оруулалттай
Улсын бүртгэлийн дугаар	
Регистрийн дугаар	
Үйл ажиллагааны цэвэр ашиг	₮
Үнэт цаас гаргагч компанид оруулсан хөрөнгийн хэмжээ, хувь	₮ ..... буюу % .....
Хаяг байршил	Аймаг/ хот
	Сум/дүүрэг
	Баг/хороо
	Гудамж, байр
	Тоот
	Холбоо барих утас

Цахим хуудас							
Цахим хаяг							
Компанийн тухай хуулийн 6.14-д заасан компанийн нэгдлийн оролцогч эсэх?					Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>	
Тийм бол доорх мэдээллийг нэгдлийн оролцогч бүрээр бөглөнө үү.							
Оноосон нэр							
Хуулийн этгээдийн хэлбэр		<input type="checkbox"/> Хувьцаат компани		<input type="checkbox"/> Хязгаарлагдмал хариуцлагатай компани			
Үнэт цаас гаргагчийн үүсгэн байгуулагчтай ямар холбоотой болох		<input type="checkbox"/> толгой <input type="checkbox"/> охин		<input type="checkbox"/> хараат <input type="checkbox"/> зэргэлдээ			
Байгуулагдсан огноо		Он		Сар		Өдөр	
Үйл ажиллагааны төрөл							
Хаяг		Аймаг/ хот					
		Сум/дүүрэг					
		Баг/хороо					
		Гудамж, байр					
		Тоот					
Холбоо барих утас							
Цахим хуудас:							
Цахим хаяг:							
<b>1.1.2. Иргэн бол түүний</b>							
Овог							
Нэр							
Иргэний харьяалал							
Регистр /паспорт/-ийн дугаар							
Албан ёсны хаяг байршил							
Эрхэлж байгаа ажил, албан тушаал							
Ажлын хаяг							
Эзэмисэн мэргэжил							
Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ		₮					
Харилцах дансны үлдэгдэл		₮					
Хадгаламжийн дансны үлдэгдэл		₮					
<b>1.2. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН МЭДЭЭЛЭЛ</b>							
Хуулийн этгээдийн нэр		Монгол Англи					
Үүсгэн байгуулагдсан огноо		Он		Сар		Өдөр	
Хуулийн этгээдийн хэлбэр		<input type="checkbox"/> Хувьцаат компани <input type="checkbox"/> Хязгаарлагдмал хариуцлагатай компани					
Хөрөнгө оруулалтын хэлбэр		<input type="checkbox"/> Дотоодын хөрөнгө оруулалттай <input type="checkbox"/> Гадаадын хөрөнгө оруулалттай					
Улсын бүртгэлийн дугаар							
Регистрийн дугаар							
Үйл ажиллагааны чиглэл							
Хаяг байршил		Аймаг/ хот					
		Сум/дүүрэг					
		Баг/хороо					
		Гудамж, байр					
		Тоот					

		<i>Холбоо барих утас</i>				
Тэмдэглэл: Монгол улсад төлөөлөгчийн газартай бол түүний хаягийг мөн бичнэ						
<i>Цахим хуудас:</i>						
<i>Цахим хаяг:</i>						
<i>Холбоо барих утас:</i>						
<b>Гаргасан хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг дангаараа эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшдэг хувьцаа эзэмшигчийн талаарх мэдээлэл:</b>						
<i>Хувьцаа эзэмшигчдийн овог, нэр /хуулийн этгээд бол оноосон нэр/</i>	<i>Хувьцааны тоо (ш)</i>	<i>Хувьцааны төрөл</i>		<i>ХНХ-н хэмжээ (₮)</i>	<i>ХНХ-д эзлэх хувь (%)</i>	
		<input type="checkbox"/> ДЭХ*	<input type="checkbox"/> ЭХ**			
		<input type="checkbox"/> ДЭХ	<input type="checkbox"/> ЭХ			
		<input type="checkbox"/> ДЭХ	<input type="checkbox"/> ЭХ			
Тэмдэглэл: (Дээрх мэдээллийг хувьцаа эзэмшигч бүрээр бичнэ. 5 болон түүнээс дээш хувийг аж ахуйн нэгж эзэмшдэг бол түүний хяналтын багц эзэмшигч бенефициар өмчлөгчийг мөн бичнэ.) * ДЭХ-давуу эрхийн хувьцаа ** ЭХ-энгийн хувьцаа						
<i>Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн мэдээлэл</i>						
#	Овог	Нэр	РД	Утас	Мэргэжил	Хараат, хараат бус
1						
2						
3						
4						
5						
6						
7						
8						
9						
<i>Нэр дэвшүүлэх хорооны гишүүдийн мэдээлэл</i>						
1						
2						
3						
<i>Цалин урамшуулалын хорооны гишүүдийн мэдээлэл</i>						
1						
2						
3						
<i>Аудитын хорооны гишүүдийн мэдээлэл</i>						
1						
2						
3						

Санхүүгийн зохицуулах хорооны нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд дараах үнэт цаасыг бүртгүүлэхээр энэхүү өргөдлийг гаргаж байна. Үнэт цаасны бүртгэлийн журамд заасан холбогдох ... хуудас баримт бичгийг хавсарган хүргүүлэв.

## 2. ҮНЭТ ЦААСНЫ МЭДЭЭЛЭЛ

2.1. Үнэт цаасны нэр:

2.2. Өмнө аль нэгэн хөрөнгийн биржид бүртгэлтэй эсэх болон үнэт цаас гаргасан улс, бүртгэлтэй хөрөнгийн бирж:

2.3. Өмнө нийтэд санал болгон үнэт цаас гаргахыг зөвшөөрсөн эрх бүхий байгууллага, түүнийг бүртгэсэн хөрөнгийн биржийн шидвэрийн дугаар, огноо:

2.4. Өмнө гаргасан үнэт цаасны төрөл, нэрлэсэн үнэ, тоо ширхэг, код, ISIN код:

2.5. Анх удаа эсхүл нэмж гаргах үнэт цаасны төрөл:

2.6. Үнэт цаасаа гаргах арилжаа эрхлэх байгууллага:

2.7. Тоо ширхэг:

2.8. Нэрлэсэн үнэ:

2.9. Хугацаа, хүү, үндсэн болон хүүгийн төлбөр төлөх хугацаа

---

2.10. Үнэт цааснынийтэд санал болгох хувь хэмжээ, хэлбэр, үнэ:

2.11. Үнэт цаас гаргах замаар олон нийтээс татан төвлөрүүлэхээр тооцсон хөрөнгийн хэмжээ:

2.12. Үнэт цаасны нөхцөл /хямдруулсан, хөвөх, тогтмол хүүтэй, хугацаанаас нь өмнө эргүүлэн татах г.м./:

2.13. Үнэт цаасыг нийтэд санал болгон арилжихаар төлөвлөсөн хугацаа:

2.14. Үнэт цаас гаргах замаар олон нийтээс татан төвлөрүүлэх хөрөнгийн зориулалтын талаарх товч мэдээлэл:

### **3. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИД МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨГӨӨ ӨГСӨН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН МЭДЭЭЛЭЛ**

3.1.1. Андеррайтерийн оноосон нэр  
/синдикат хэлбэрээр оролцож байгаа бол энэ болон дараах мэдээллийг мөн бичнэ/:

3.1.2. Бүртгэлтэй улс, улсын бүртгэлийн дугаар:

3.1.3. Регистрийн дугаар:

---

3.1.4. Эрх бүхий байгууллагаас олгосон энэхүү үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрлийн дугаар, огноо:

3.1.5. Оршин байх албан ёсны хаяг /Монгол Улсад төлөөлөгчийн газартай бол түүний хаягийг мөн бичнэ/:

3.1.6. Шуудангийн болон цахим шуудангийн хаяг, холбоо барих утас:

3.2.1. Хуулийн зөвлөгөө өгсөн компанийн оноосон нэр:

3.2.2. Бүртгэлтэй улс, бүртгэлийн дугаар:

3.2.3. Регистрийн дугаар:

3.2.4. Эрх бүхий байгууллагаас олгосон энэхүү үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрлийн дугаар, огноо:

3.2.5. Оршин байх албан ёсны хаяг  
/Монгол Улсад төлөөлөгчийн газартай бол түүний хаягийг мөн бичнэ/:

3.2.6. Шуудангийн болон цахим шуудангийн хаяг, холбоо барих утас:

3.3. Үнэт цаас гаргагч нь энэхүү үнэт цаас гаргахтай холбоотойгоор ямар нэгэн хөндлөнгийн шинжээч, мэргэжилтэнтэй гэрээ байгуулан ажилласан болон энэ

тухай мэдээлэл:

--

Энэхүү өргөдөл, түүнд хавсарган хүргүүлсэн баримт бичгийн үнэн зөвийг өргөдөл гаргагч бид бүрэн хариуцах бөгөөд хөрөнгө оруулагчид тохиолдож болзошгүй эрсдэл, хөрөнгө оруулагчдад хүргэвэл зохих мэдээллийг үнэт цаасны танилцуулгад үнэн зөв, бүрэн тусгасан болно.

Өргөдөлгаргасан:

<p>1. Овог, нэр:.....</p> <p>Албан тушаал: Үнэт цаас гаргагч “.....” –.....К-ийн ТУЗ-ийн дарга</p> <p>Гарын үсэг:.....</p> <p>(Тамга/тэмдэг)</p>	<p>4. Овог, нэр:.....</p> <p>Албан тушаал: ..... андеррайтерийн компанийн ТУЗ-ийн дарга</p> <p>Гарын үсэг:.....</p> <p>(Тамга/тэмдэг)</p>
<p>2. Овог, нэр:.....</p> <p>Албан тушаал: Үнэт цаас гаргагч “.....” –.....К-ийн гүйцэтгэх захирал</p> <p>Гарын үсэг:.....</p> <p>(Тамга/тэмдэг)</p>	<p>5. Овог, нэр:.....</p> <p>Албан тушаал: .....андеррайтерийн компанийн гүйцэтгэх захирал</p> <p>Гарын үсэг:.....</p> <p>(Тамга/тэмдэг)</p>
<p>3. Овог, нэр:.....</p> <p>Албан тушаал: Үнэт цаас гаргагч</p>	<p>6. Овог, нэр:.....</p> <p>Албан тушаал: ..... хуулийн зөвлөх“.....” –ХХК-ийн</p>

<p>“.....” –.....К-ийн Ерөнхий нягтлан бодогч</p> <p>Гарын үсэг:.....</p> <p>(Тамга/тэмдэг)</p>	<p>гүйцэтгэх захирал</p> <p>Гарын үсэг:.....</p> <p>(Тамга/тэмдэг)</p>
---	--

*Өргөдөл гаргасан огноо:.....*

*Өргөдөлтэй холбоотой асуудлыг  
хариуцан ажиллах ажилтны овог  
нэр, албан тушаал, холбоо барих  
утас:*

--

**ТУСГАЙ ТЭМДЭГЛЭЛ /зөвхөн Санхүүгийн зохицуулах хорооны ажилтан бөглөнө/**

<p><i>Өргөдөл хүлээн авсан ажилтаны овог нэр:</i></p>	<p><i>Өргөдөл хүлээн авсан огноо, цаг, минут:</i></p>	<p><i>Өргөдөл түүнд хавсаргасан баримтын тоо /нүүрээр/:</i></p>
---	---	---

Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн ... дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 2 дугаар хавсралт

Маягт СЗХ03102

**“.....” (Х)ХК-ИЙН АРИЛЖААНД ОРУУЛАХЫГ ЗӨВШӨӨРСӨН  
ҮНЭТ ЦААСЫГ БҮРТГЭСЭН, ҮНЭТ ЦААСНЫ БҮРДҮҮЛБЭРТ ӨӨРЧЛӨЛТ  
ОРУУЛСАН ТУХАЙ ДҮГНЭЛТ**

Огноо: ...../...../.....

Он, сар, өдөр

Санхүүгийн зохицуулах хороонд

**1. АРИЛЖАА ЭРХЛЭХ БАЙГУУЛЛАГЫН МЭДЭЭЛЭЛ**

Хуулийн этгээдийн нэр			
Улсын бүртгэлийн дугаар			
Регистрийн дугаар			
Үнэт цаасны арилжаа эрхлэх үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл авсан огноо, Санхүүгийн зохицуулах хорооны шийдвэрийн дугаар:			
Гүйцэтгэх захирлын овог, нэр:			
Хаяг байршил	Аймаг/ хот		
	Сум/дүүрэг		
	Баг/хороо		
	Гудамж, байр		
	Тоот		
Холбоо барих утас			
Цахим хуудас:			
Цахим хаяг:			

**2. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН МЭДЭЭЛЭЛ**

Хуулийн этгээдийн нэр	Монгол				
	Англи				
Үүсгэн байгуулагдсан огноо	Он		Сар		Өдөр
Хуулийн этгээдийн хэлбэр	<input type="checkbox"/> Хувьцаат компани				
	<input type="checkbox"/> Хязгаарлагдмал хариуцлагатай компани				
Хөрөнгө оруулалтын хэлбэр	<input type="checkbox"/> Дотоодын хөрөнгө оруулалттай				

	<input type="checkbox"/> Гадаадын хөрөнгө оруулалттай	
Улсын бүртгэлийн дугаар		
Регистрийн дугаар		
Үйл ажиллагааны чиглэл		
Бүртгүүлсэн үнэт цаасны	нэр	
	төрөл	
	тоо ширхэг	
	нэрлэсэн үнэ	
	хугацаа	
	хүү	
	хүү төлөгдөх нөхцөл	
	үндсэн төлбөр төлөгдөх нөхцөл	
	код	
ISIN код		
Татан төвлөрүүлэх хөрөнгийн дүн	₮	
Нийтэд санал болгох хувь	%	
Арилжаа эрхлэх байгууллагын ангилал		
Хаяг байршил	Аймаг/ хот	
	Сум/дүүрэг	
	Баг/хороо	
	Гудамж, байр	
	Тоот	
	Холбоо барих утас	
Тэмдэглэл: Монгол улсад төлөөлөгчийн газартай бол түүний хаягийг мөн бичнэ		
Цахим хуудас:		

### 3. ҮНЭТ ЦААС ГАРГАХТАЙ ХОЛБООТОЙ ХИЙГДСЭН АЖЛЫН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

3.1. Үнэт цаас гаргагчийн хүсэлт гаргасан огноо	Он		Сар		Өдөр	
3.2. Үнэт цаас гаргагчийн хүргүүлсэн баримт бичгийг хянасан ажилтаны	Нэр	Албан тушаал				

3.3. Үнэт цаасыг бүртгэхтэй холбоотой

--

үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтан, түүний мэргэжлийн зөвлөхтэй уулзалт, тэдгээрээс танилцуулга хийсэн эсэх талаарх мэдээлэл, уулзалтын огноо, оролцогч талуудын мэдээлэл, хэлэлцсэн асуудал:

--

3.4. Арилжаа эрхлэх байгууллагаас үнэт цаас гаргагчид нэмэлт баримт бичиг, талбар, тодруулга хүссэн албан бичиг хүргүүлсэн эсэх /тийм бол огноо, дугаар болон албан бичиг тус бүрийн хуулбарыг энэхүү дүгнэлтэд хавсаргана./

--

3.5. Үнэт цаас гаргагчаас арилжаа эрхлэх байгууллагын шаардлагын дагуу хариу хүргүүлсэн эсэх /тийм бол огноо, дугаар болон албан бичиг тус бүрийн хуулбарыг энэхүү дүгнэлтэд хавсаргана./

--

3.6. Өөр улсын арилжаа эрхлэх байгуулагад бүртгэлтэй эсэх, давхар бүртгүүлэн арилжаалагдах боломжтой эсэх:

--

3.7. Эргэлтэнд гаргасан үнэт цаасны тоо:

--

3.8. Эргэлтэд гаргах үнэт цаасны тоо, ширхэг, татан төвлөрүүлэхээр төлөвлөсөн хөрөнгийн хэмжээ:

--

3.9. Үнэт цаасыг үе шаттай гаргах эсэх, түүнийг гаргах хугацаа, хуваарь:

--

3.10. Үнэт цаас гаргагчийн олон нийтэс татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт болон

---

*хөрөнгө оруулагчийн эрх, үүргийн талаарх мэдээлэл:*

--

*3.11. Үнэт цаас гаргагчийн цаашид явуулах үйл ажиллагаанд учирч болох эрсдэл, түүнийг хэрхэн удирдах талаарх хүсэлт гаргагчаас ирүүлсэн мэдээлэл, төлөвлөгөөнд өгөх арилжаа эрхлэх байгууллагын дүгнэлт:*

--

*3.12. Нэмэлт тайлбар /шаардлагатай бол/:*

--

*Жич: “.....” –ийн /арилжаа эрхлэх байгууллагын нэр/ ..... /эрх бүхий байгууллага/-ийн ..... /огноо/-ны өдрийн ..... дугаар тогтоолоор батлагдсан “Бүртгэлийн журам”-ийн дагуу үнэт цаас гаргагчаас ирүүлсэн баримт бичгийг хянасан тухай ‘хяналтын жагсаалт’ /нийт .... хуудас/-ыг хавсаргав.*

Дүгнэлт гаргасан:

Овог, нэр: .....	Овог, нэр: .....
Албан тушаал: .....	Албан тушаал: .....
	Гарын үсэг: .....

Гарын үсэг: .....	
Овог, нэр: ..... Албан тушаал: ..... Гарын үсэг: .....	Овог, нэр: ..... Албан тушаал: ..... Гарын үсэг: .....
Хянасан: Овог, нэр: ..... “.....”-ийн гүйцэтгэх захирал Гарын үсэг: ..... (Тамга/тэмдэг)	

“.....”/арилжаа эрхлэх байгууллагын нэр/-ийн арилжаанд оруулахыг зөвшөөрсөн үнэт цаасыг бүртгэсэн,  
 үнэт цаасны бүрдүүлбэрт өөрчлөлт оруулсан тухай дүгнэлтийн ХАВСРАЛТ

ҮНЭТ ЦААСЫГ БҮРТГЭХ, БҮРДҮҮЛБЭРТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ХҮСЭЛТИЙН  
 ХЯНАЛТЫН ХУУДАС

Үнэт цаас гаргагчийн нэр: .....

Андеррайтерийн нэр: .....

Д/д	Журмын		Бүртгэлийн шаардлага хангасан эсэх*	Тайлбар	Үнэт цаасны танилцуулга дахь хуудасны	
	Заалтын дугаар	Заалт			дугаар	тоо
1						
2						
3						

\*- 'тийм' эсхүл 'үгүй' тэмдэглэл хийнэ

Маягт СЗХ03103

**ҮНЭТ ЦААСЫГ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛД  
САНАЛ БОЛГОСОН ТУХАЙ ТАЙЛАН**

Огноо: ...../...../.....

Он, сар, өдөр

Санхүүгийн зохицуулах хороонд

**1. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН МЭДЭЭЛЭЛ**

Хуулийн этгээдийн нэр	Монгол	
	Англи	
Бүртгүүлсэн үнэт цаасны	нэр	
	төрөл	
	тоо ширхэг	
	нэрлэсэн үнэ	
	хугацаа	
	хүү	
	хүү төлөгдөх нөхцөл	
	үндсэн төлбөр төлөгдөх нөхцөл	
	код	
	ISIN код	
Арилжаа эрхлэх байгууллагын ангилал		
Арилжаанд оруулахыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгэсэн арилжаа эрхлэх байгууллагын шийдвэрийн огноо, дугаар:		
Нийтэд санал болгон үнэт цаас гаргахыг зөвшөөрсөн эрх бүхий зохицуулагч байгууллагын шийдвэрийн огноо, дугаар:		
Зохицуулагч байгууллагаас анхдагч зах зээлийн арилжааг эхлүүлэхийг		

зөвшөөрсөн албан тоотын огноо, дугаар:		
Хаяг байршил	Аймаг/ хот	
	Сум/дүүрэг	
	Баг/хороо	
	Гудамж, байр	
	Тоот	
	Холбоо барих утас	
Тэмдэглэл: Монгол улсад төлөөлөгчийн газартай бол түүний хаягийг мөн бичнэ		
Цахим хуудас:		

## 2. АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖААТАЙ ХОЛБООТОЙ МЭДЭЭЛЭЛ

2.1. Анхдагч зах зээлд арилжаалсан  Арилжаа эрхлэх байгууллагаар хэлбэр:

/Энэхүү хэлбрээр анхдагч зах зээлд арилжаалсан бол зохих журмын дагуу явагдсан талаар арилжаа эрхлэх байгууллагын дүгнэлтийг хавсаргана./

Захилгын бүртгэлийн аргаар

2.2. Анхдагч зах зээлд арилжаалж эхэлсэн болон дууссан огноо:

2.3. Нийтэд санал болгон арилжаалсан нэгж хувьцааны үнэ /дээд, доод, дундаж ханиш/:

2.4. Үнэт цаасыг хаалттай захиалгын хүрээнд санал болгон худалдсан бол нэгж хувьцааны үнэ болон хаалттай хүрээнд санал болгон арилжсан тоо, хувь /энэ хэсэгт үнэт цаасыг тэргүүн ээлжинд худалдан авсан хувьцаа эзэмшигчийн мэдээлэл мөн хамаарна/:

2.5. Ажиллагсдад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр /ESOP/ хэрэгжүүлсэн бол нэгж хувьцааг тооцсон үнэ,

тэдгээрт эзэмшүүлсэн хэмжээ:

2.6. Үнэт цаасны талицуулгад заасан амжилтын хувьд хүрэлцэхүйц хөрөнгийг татан төвлөрүүлсэн эсэх

2.7. Нэмэлт тайлбар /шаардлагатай бол/:

Тайлан гаргасан:

Овог, нэр: ..... Албан тушаал: Үнэт цаас гаргагч “.....” ХК-ийн ТУЗ-ийн дарга Гарын үсэг: ..... (Тамга/тэмдэг)	Овог, нэр: ..... Албан тушаал: “.....” Андеррайтерийн компанийн ТУЗ-ийн дарга Гарын үсэг: ..... (Тамга/тэмдэг)
Овог, нэр: ..... Албан тушаал: Үнэт цаас гаргагч “.....” ХК-ийн гүйцэтгэх захирал Гарын үсэг: ..... (Тамга/тэмдэг)	Овог, нэр: ..... Албан тушаал: “.....” Андеррайтерийн компанийн гүйцэтгэх захирал Гарын үсэг: ..... (Тамга/тэмдэг)

**“.....” (Х)ХК-ИЙН АРИЛЖААНД ОРУУЛАХЫГ ЗӨВШӨӨРСӨН ҮНЭТ ЦААСЫГ БҮРТГЭЛЭЭС ХАССАН ТУХАЙ ДҮГНЭЛТ**

Огноо: ...../...../.....

Он, сар, өдөр

Санхүүгийн зохицуулах хороонд

**1. АРИЛЖАА ЭРХЛЭХ БАЙГУУЛЛАГЫН МЭДЭЭЛЭЛ**

Хуулийн этгээдийн нэр		
Улсын бүртгэлийн дугаар		
Регистрийн дугаар		
Үнэт цаасны арилжаа эрхлэх үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл авсан огноо, Санхүүгийн зохицуулах хорооны шийдвэрийн дугаар:		
Гүйцэтгэх захирлын овог, нэр:		
Хаяг байршил	Аймаг/ хот	
	Сум/дүүрэг	
	Баг/хороо	
	Гудамж, байр	
	Тоот	
Холбоо барих утас		
Цахим хуудас:		
Цахим хаяг:		

**2. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН МЭДЭЭЛЭЛ**

Хуулийн этгээдийн нэр	Монгол	
	Англи	
Бүртгүүлсэн үнэт цаасны	нэр	
	төрөл	
	тоо ширхэг	
	нэрлэсэн үнэ	
	хугацаа	
хүү		

	<i>хуу төлөгдөх нөхцөл</i>	
	<i>үндсэн төлбөр төлөгдөх нөхцөл</i>	
	<i>код</i>	
	<i>ISIN код</i>	
<i>Арилжаа эрхлэх байгууллагын ангилал</i>		
<i>Хаяг байршил</i>	<i>Аймаг/ хот</i>	
	<i>Сум/дүүрэг</i>	
	<i>Баг/хороо</i>	
	<i>Гудамж, байр</i>	
	<i>Тоот</i>	
	<i>Холбоо барих утас</i>	
<i>Тэмдэглэл: Монгол улсад төлөөлөгчийн газартай бол түүний хаягийг мөн бичнэ</i>		
<i>Цахим хуудас:</i>		
<i>Эрхэлж байгаа үйл ажиллаагааны талаарх дэлгэрэнгүй мэдээлэл /сүүлийн 3 жилийн санхүүгийн үзүүлэлтийг энэхүү дүгнэлтэд хавсаргана/</i>		

### **3. ҮНЭТ ЦААСЫГ БҮРТГЭЛЭЭС ХАССАНТАЙ ХОЛБООТОЙ ХИЙГДСЭН АЖЛЫН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ**

<i>3.1. Үнэт цаас гаргагчийн хүсэлт гаргасан огноо</i>	<i>Он</i>		<i>Сар</i>		<i>Өдөр</i>	
<i>3.2. Үнэт цаас гаргагчийн хүргүүлсэн баримт бичгийг хянасан ажилтаны</i>	<i>Нэр</i>	<i>Албан тушаал</i>				

3.3. *Үнэт цаасыг бүртгэлээс хасахтай холбоотой үнэт цаас гаргагчийн эрх бүхий байгууллага, шийдвэрийн огноо, дугаар:*

3.4. *Арилжаа эрхлэх байгууллагаас үнэт цаас гаргагчид нэмэлт баримт бичиг, талбар, тодруулага хүссэн албан бичиг хүргүүлсэн эсэх /тийм бол*

огноо, дугаар болон албан бичиг тус бүрийн хуулбарыг энэхүү дүгнэлтэд хавсаргана./

3.5. Үнэт цаас гаргагчаас арилжаа эрхлэх байгууллагын шаардлагын дагуу хариу хүргүүлсэн эсэх /тийм бол огноо, дугаар болон албан бичиг тус бүрийн хуулбарыг энэхүү дүгнэлтэд хавсаргана./

3.6 Өөр улсын арилжаа эрхлэх байгуулагад бүртгэлтэй эсэх, тийм бол түүний бүртгэлээс хасагдсан эсэх:

3.7. Эргэлтэнд гаргасан үнэт цаас болон нийт хувьцаа эзэмшигчдийн тоо:

3.8. Компанийн 5 болон түүнээс дээш хувь эзэмшигчдийн нэр(с):

3.9. Арилжаа эрхлэх байгууллагын эрх бүхий албан тушаалтны үнэт цаасыг бүртгэлээс хасах тухай шийдвэрийн огноо, дугаар:

3.10. Үнэт цаас гаргагчийн үнэт цаасаа бүртгэлээс хасуулах асуудлыг хэлэлцсэн хувьцаа эзэмшигчдийн хуралтай холбоотой мэдээлэл /ирц, хэлэлцсэн асуудал, хаяг, шийдвэр гаргасан хувь г.м/ бүртгэлээс хасагдах үндэслэл, шалтгаан:

3.11. *Компанийг өөрчлөн байгуулах төсөлд заасан өөрчлөн байгуулах арга хэлбэр, нэгж хувьцааны зах зээлийн үнэ, түүнийг тогтоосон үндэслэл, эрх бүхий этгээдийн шийдвэр, компанийн тухай хуульд заасан хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрэгжүүлэх журмын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл*

3.12 *Компанийн хэлбэрийг өөрчилсөнтэй холбоотойгоор хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрэгжүүлсэн тухай мэдээлэл, уг ажиллагаанд өгөх арилжаа эрхлэх байгууллагын дүгнэлт:*

3.13. *Нэмэлт тайлбар /шаардлагатай бол/*

--

Дүгнэлт гаргасан:

Овог, нэр: .....	Овог, нэр: .....
Албан тушаал: .....	Албан тушаал: .....
Гарын үсэг: .....	Гарын үсэг: .....
Овог, нэр: .....	Овог, нэр: .....
Албан тушаал: .....	Албан тушаал: .....
Гарын үсэг: .....	Гарын үсэг: .....
Хянасан:	
Овог, нэр: .....	
“.....”-ийн гүйцэтгэх захирал	
Гарын үсэг: .....	
(Тамга/тэмдэг)	